

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



Аудит хийх үндэслэл: Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны “Аудитын сэдэв батлах тухай” 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны “Аудитын ажлын төлөвлөгөө батлах тухай” А/12 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуульд тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдэлсэн “Дарьт шүтээн” ХХК борлуулалтын орлогоо 30.7 сая төгрөгөөр дутуу тайлагнасан зөрчил дутагдал илэрлээ



Аудитын нэр:

“Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлого, түүний хэрэгжилт, үр дүн”

**Баруун-Урт сум
2017 он**

АГУУЛГА

Аудитын тайланг бэлтгэсэн:

ААГ-ын аудитын хэлтэс

Сүхбаатар
аймаг дахь
Төрийн
аудитын
газрын дарга, М.Нарантуяа
тэргүүлэх
аудитор

Аудитын менежер Г.Даваа

Ахлах аудитор С.Ариунбаяр
Аудитор Б.Ариунзул
Аудитор Ө.Золзаяа

2017 оны 09 дүгээр сарын 4-ны өдөр

Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал багийн утас 70512123, 70512127

Газрын дарга, тэргүүлэх аудитор 70518396 дугаарын факсаар харилцана уу

ХАЯГ:

Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газар, Баруун-Урт сум, 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, өрөө №226 тоот

Сүхбаатар аймаг
Баруун –Урт хот

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт

Товчилсон үгийн тайлбар

1.1 Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдэлсэн Дарьт шүтээн ХХК борлуулалтын орлогоо 30.7 сая төгрөгөөр дутуу тайлагнасан зөрчил дутагдал илэрлээ

1.2 Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдсан аж ахуйн нэгж байгууллагын талаарх мэдээллийг хууль, тогтоомжид заасны дагуу иргэдэд нээлттэй мэдээллээгүй байна

2.1 Аймгийн хэмжээнд ХХОАТ-ын хөнгөлөлт чөлөөлөлтөд 2015, 2016 онуудад 1261.9 сая төгрөг олгож, НӨАТ-аас 2132.1 сая төгрөгийн борлуулалтын орлогыг чөлөөлжээ

2.2 Аймгийн Татварын хэлтэсээс татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн байдалд хийх хяналт, шалгалт хангалтгүй байна

Аудитын дүгнэлт:

Аудитын зөвлөмж:

Аудитын санал:

Холбогдох байгууллагын санал

Аудитын газрын тайлбар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудит хийх үндэслэл

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны “Аудитын сэдэв батлах тухай” 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны “Аудитын ажлын төлөвлөгөө батлах тухай” А/12 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуульд тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлого, түүний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад дараах чиглэлийг нарийвчлан авч үзэж, үнэлэлт дүгнэлт өгөв. Үүнд:

- Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг хэрэгжүүлэгч байгууллагууд харилцан уялдаатай ажиллаж чадаж байгаа эсэх
- Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг зохих хууль журмын дагуу хэрэгжүүлсэн эсэх

Аудит хамарсан хүрээ

Аудитад Сүхбаатар аймгийн хэмжээнд 2015-2016 онд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдэлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, тэдгээрийн судалгаа, бүртгэл тайлагнал, статистик мэдээ, аймгийн Татварын хэлтсийн үйл ажиллагааны баримт бичгүүдийг хамруулан шалгалаа.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100), Гүйцэтгэлийн аудитын журмыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан, аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж дүн шинжилгээ хийн аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
ГА	Гүйцэтгэлийн аудит
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
ЗБН	Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл
НББ	Нягтлан бодох бүртгэл
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
СБА	Сүхбаатар аймаг
ТЕГ	Татварын ерөнхий газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

1

БҮЛЭГ 1

Дэд зорилт-1. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг хэрэгжүүлэгч байгууллагууд харилцан уялдаатай ажиллаж чадаж байна уу

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлогыг нийтэд хангалтгүй мэдээлсэн, зарим аж ахуйн нэгж байгууллага борлуулалтын орлогоо дутуу тайлагнаж, НӨАТ-аас чөлөөлөгдөх орлогыг илүү илэрхийлсэн зөрчил дутагдал илэрлээ

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдэлсэн “Дарьт шүтээн” ХХК борлуулалтын орлогоо 30.7 сая төгрөгөөр дутуу тайлагнасан зөрчил дутагдал илэрлээ

1.1.1 Татварын хөнгөлөлт чөлөөлөлтөнд хамрагдсан аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд түүвэрлэн аудит хийхэд “Дарьт Шүтээн” ХХК 2015 оны борлуулалтын орлогоо 30.7 сая төгрөгөөр дутуу, НӨАТ-аас чөлөөлөгдөх орлогыг 8.9 сая төгрөгөөр илүү илэрхийлсэн зөрчил дутагдал илэрсэн. “Жавхлант Сүхбаатар” ХХК нь НӨАТ-аас чөлөөлөгдөх 29.0 сая төгрөгийн борлуулалтын орлогоо үнэн зөв илэрхийлээгүй нь Татварын ерөнхий хуулийн 18.1.1¹, “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай” хуулийн 21.1² дэх заалт, НӨАТ-ын тухай хуулийн 13 дугаар зүйлийг зөрчжээ. Иймд дээрх зөрчил дутагдлыг аймгийн Татварын хэлтэсийн хяналт шалгалтын тасагт шилжүүлэн шалгуулж, уг зөрчлийг арилгуулах, арга хэмжээ авах хугацаатай албан шаардлага хүргүүлээ.

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдсан аж ахуйн нэгж байгууллагын талаарх мэдээллийг хууль, тогтоомжид заасны дагуу иргэдэд нээлттэй мэдээлэл өгөөгүй байна

1.2.1 Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлого, түүний хэрэгжилт, хууль, тогтоомжийг нийтэд мэдээллэх, сурталчилах ажлууд хангалтгүй хийгдэж байна. Татвар төлөгч байгууллага, иргэн татварын цахим сайтаар дамжуулан мэдээ, мэдээллийг авч байгаа боловч бусад хэлбэрээр мэдээ мэдээлэл өгөх шаардлагатай байна. Аймгийн Татварын хэлтэсээс татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаар хэрэгжүүлж буй бодлогыг сурталчилах, аж ахуйн нэгж байгууллагуудын татвар төлөлт, үйл ажиллагааны талаарх мэдээ мэдээллийг олон нийтэд хангалтгүй хүргэж байна. Мөн хуулиар хориглоогүй мэдээлэх ёстой мэдээллийг хүргэлгүй Татварын ерөнхий хуулийн 13.3³ дахь заалтыг баримтлан хувь хүн, байгууллагын нууцлалтай холбоотой гэх шалтгаанаар үйл ажиллагааныхаа цар хүрээг багасгаж байна.

¹ татвар ногдох зүйл, татвараа үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх

² Албан татвар төлөгч нь нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар гаргасан улирал, жилийн татварын тайланг үндэслэн жилийн эхнээс өссөн дүнгээр орлого болон төлөх албан татвараа өөрөө үнэн зөв тодорхойлж төсөвт төлнө.

³ Татварын алба, татварын улсын байцаагч, татварын албаны бусад ажилтан нь албан үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн Хувь хүний нууцын тухай хууль болон Байгууллагын нууцын тухай хуулиар тодорхойлсон татвар төлөгчийн нууцыг хадгалах үүрэгтэй бөгөөд зөвхөн төрийн байгууллагын дор дурдсан албан тушаалтанд татварын албаны даргын шийдвэрээр танилцуулж болно

1.2.2 Татварын хэлтэсээс татвар төлөгч иргэн болон аж ахуйн нэгжийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад дээд шатны байгууллагуудаас батлан гаргасан хууль тогтоомж, журам, тушаал заавар түүний өөрчлөлтийн талаар тухай бүр сургалт сурталчилгаа зохион байгуулж, хэрэгжилтийг хангуулах тал дээр хангалтгүй ажиллажээ.

Дэд зорилт-2. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг зохих хууль журмын дагуу хэрэгжүүлсэн эсэх

2

БҮЛЭГ 2

ХХОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлтийг хуулийн дагуу хэрэгжүүлж байгаа боловч татварын дотоод хяналт хангалтгүй, цахим системийн мэдлэг дутмагаас аж ахуйн нэгж байгууллага борлуулалтын орлогоо илүү, дутуу тайлагнах, хөнгөлөлт, чөлөөлөлтийг буруу мэдээлэх зэрэг зөрчил гаргасан байна

Аймгийн хэмжээнд ХХОАТ-ын хөнгөлөлт чөлөөлөлтөд 2015, 2016 онуудад 1261.9 сая төгрөг олгож, НӨАТ-аас 2132.1 сая төгрөгийн борлуулалтын орлогыг чөлөөлжээ

2.1.1 Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдсан 2 төрлийн татварын зүйл байгаагаас ХХОАТ болон НӨАТ-ууд уг аудитад хамрагдаж байна. Сүхбаатар аймгийн хэмжээнд 2015-2016 онд ХХОАТ-ын тухай хуулийн 16.1.12⁴, 24.6⁵ дахь заалтын дагуу давхардсан тоогоор 2385 иргэн 1261.9 сая төгрөгийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдэлжээ. Үүнийг хүснэгтээр харуулав. (Хүснэгт №1)

№	ХХОАТ-ын тухай хуулийн заалт	2015 он		2016 он	
		Хамрагдсан хүний тоо	Чөлөөлсөн татварын дүн /сая.төг/	Хамрагдсан хүний тоо	Чөлөөлсөн татварын дүн /сая.төг/
1	16 дугаар зүйлийн 16.1.12	674	489.8	754	542.3
2	16 дугаар зүйлийн 24.6	410	78.1	464	95.9
3	16 дугаар зүйлийн 16.1.12, 24.6	40	27.2	43	28.6
	НИЙТ	1124	595.1	1261	666.8

2.1.2 ХХОАТ-ын 16.1.12, 24.6 дахь заалтын дагуу хөнгөлөлт чөлөөлөлт эдэлсэн иргэдийн судалгааг гаргахдаа иргэдийн тоог 24, олгосон хөнгөлөлт, чөлөөлөлтийн мөнгөн дүнг 16.2 сая төгрөгөөр хооронд нь зөрүүтэй нэгтгэжээ.

⁴ хувь хүн өөрийн орлого болон банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хөрөнгөөр амьдран суух зориулалтаар анх удаа хувьдаа орон сууцны барилга барих, эсхүл худалдан авахад зарцуулсан 30.0 сая төгрөгөөс дээшгүй хэмжээний хөрөнгөтэй тэнцэх орлого

⁵ Албан татвар төлөгчийн төрсөн буюу үрчилсэн хүүхэд гадаад, дотоодын их, дээд болон мэргэжлийн боловсролын сургууль, коллежид элсэн суралцаж байгаа бол түүний сургалтад төлсөн, баримтаар нотлогдож байгаа төлбөрийн хэмжээгээр албан татварын хөнгөлөлт үзүүлнэ.

2.1.3 Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдсан иргэдийн баримт материалд түүвэрлэн тулган баталгаажуулалт хийхэд 2015 онд ХХОАТ-ын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.12-д заасны дагуу татварын чөлөөлөлт эдэлсэн 1 иргэний үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлогыг 70.0 сая төгрөгийн үнийн дүнтэй мэдээллэх ёстойг 40.0 сая төгрөгөөр дутуу тайлагнасан зөрчил дутагдал илэрсэн. Уг зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх хугацаатай албан шаардлага хүргүүлээ.

2.1.4 Аймгийн хэмжээнд НӨАТ-ын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу дараах аж ахуйн нэгжүүдийн борлуулалтын орлогыг НӨАТ-аас чөлөөлсөн байна. (Хүснэгт-2)

НӨАТ-аас чөлөөлөгдсөн аж ахуйн нэгж

/сая.төг/

Аж ахуйн нэгжийн нэр	НӨАТ тухай хуулийн заалт	НӨАТ-аас чөлөөлөгдөх боруулалтын орлого		
		2015	2016	НИЙТ
Түвшинмөнх	13.5.9	13.2	4.5	17.7
	13.1.3		0.6	0.6
Талын богд	13.1.17	4.3		4.3
Дарьтшүтээн	13.1.17	38.1	27.6	65.7
Хонгор-Эрдэнэ	13.1.3	0.2		0.2
Дөрвөлж	13.1.8	31.3	3	34.3
	13.1.15	2.9		2.9
	13.5.8	3.1		3.1
	13.5.14	11.4		11.4
	13.1.18	48.2	138.7	186.9
Өөдлөх боломж	13.1.16	32.7		32.7
Үхэр-Уяа	13.1.16	1	0.9	1.9
Гүнгуу	13.1.16	0.3		0.3
Исгэрээ	13.1.17	4.9		4.9
Андин илч	13.1.13	107.1		107.1
Эрдэнийн олз	13.1.13	1616.4		1616.4
Нэмэр их	13.1.16		1.3	1.3
Өнө-Энхжин	13.1.3		1.3	1.3
Номин долгион	13.1.2		0.04	0.04
Оргих төгөлдөр	13.1.9		0.08	0.08
	13.1.15		0.09	0.09
Жавхлант Сүхбаатар	13.1.15		29	29
Гүүнзэл	13.1.16		0.9	0.9
Баруун-Урт эм хангамж	13.5.10		7	7
Датуком	13.1.3		0.05	0.05
Баруун-Урт Тансаг	13.1.3		1.9	1.9
НИЙТ		1915.1	217.0	2132.1

2.1.5 Татварын чөлөөлөлтөнд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн мэдээ, судалгааг цахим тайлангийн систем буюу BI, E-tax, Тах акт программ болон хөнгөлөлт, чөлөөлөлтөд

хамрагдсан борлуулалтын орлогыг анхан шатны баримт, НББ-тэй тулган баталгаажууллаа. 2015 онд 11 аж ахуйн нэгж 1915.1 сая, 2016 онд 13 аж ахуйн нэгж 217.0 сая нийт 2132.1 сая төгрөгийн борлуулалтын орлогыг НӨАТ ноогдуулах орлогоос чөлөөлжээ. Эдгээр аж ахуйн нэгжүүдийн борлуулалтын орлогыг түүвэрлэн анхан шатны баримт, нягтлан бодох бүртгэлтэй нь тулган баталгаажуулахад

- “Өнө-Энхжин”, “Баруун-Урт эм хангамж”, “Датуком”, “Баруун-Урт Тансаг”, “Хонгор-Эрдэнэ”, “Өөдлөх боломж” ХХК-ууд татвараас чөлөөлөгдөх орлогыг хуулийн дагуу тайлагнажээ.
- Харин “Дөрвөлж” ОНӨААТҮГ 238.6 сая, “Номин долгион” ХХК 0.04 сая төгрөгийн борлуулалтын орлогыг НӨАТ-ын тухай хуулийн 13.1.2⁶, 13.1.8⁷, 13.1.18⁸, 13.5.8⁹, 13.5.14¹⁰ заалтын дагуу татвараас чөлөөлөгдөхөөр тайлагнасан нь дээрх байгууллагын эрхэлж буй үйл ажиллагааны чиглэлтэй уялдаагүй байна. Дээрх нөхцөл байдал үүссэн нь дан ганц аж ахуйн нэгж байгууллагаас шалтгаалаагүй бөгөөд Е-TAX программд татварын чөлөөлөлт эдлэх хуулийн зүйл заалтыг бүрэн зөв оруулж өгөөгүйтэй холбоотой байна. Тухайлбал “Дөрвөлж” ОНӨААТҮГ нь дотоод үйл ажиллагаанд зарцуулсан ус, дулааны зардлыг НӨАТ-ын тухай хуулийн 13.9¹¹ дэх заалтын дагуу чөлөөлөх байтал цахим програмд тус заалт ороогүйгээс буруу заалт ашиглан тайлагнасан байна.
- Мөн “Үхэр-Уяа” ХХК 1.9 сая, “Гүнгуу” ХХК 0.3 сая, “Оргих төгөлдөр” ХХК 0.2 сая, “Гүүн зэл” ХХК 0.9 сая, “Талын богд” ЗБН 4.3 сая нийт 7.6 сая төгрөгийг НӨАТ-аас чөлөөлж тайлагнасан нь НӨАТ-ын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1¹² дэх заалтыг зөрчсөн байна. Дээрх зөрчил дутагдлыг барагдуулах, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг хуулийн дагуу тайлагнаагүй аж ахуйн нэгж байгууллагыг шалган, арга хэмжээ авах хугацаатай албан шаардлагыг Аймгийн татварын хэлтэст хүргүүлжээ.

Аймгийн Татварын хэлтэсээс татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн байдалд хийх хяналт, шалгалт хангалтгүй байна

2.2.1 Аймгийн татварын хэлтэсийн хяналтын тасаг 2015, 2016 онд 52 аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн баримт материал, татварын төлөлтийн байдалд хяналт,

⁶ Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга оршин суудаг гадаадын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, Нэгдсэн үндэсний байгууллага, түүний төрөлжсөн салбарын хэрэгцээнд зориулан импортоор оруулсан бараа

⁷ эмчилгээний зориулалтаар хэрэглэх цус, цусан бүтээгдэхүүн, эд эрхтэн

⁸ Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн, үйлдвэрлэн борлуулсан жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл

⁹ орон сууцны зориулалтаар баригдсан зориулалтын дагуу ашиглагдаж байгаа байрыг болон түүний тодорхой хэсгийг хөлслүүлэх үйлчилгээ

¹⁰ аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээд гадаад улсын аялал жуулчлалын байгууллагатай гэрээ байгуулж жуулчдыг нь хүлээн авах, уг үйлчилгээг төлөвлөх, сурталчлах, бичиг баримтыг нь бүрдүүлэх зэрэг гадаадын жуулчдад үзүүлсэн /туроператор/ үйлчилгээ

¹¹ Бараа, ажил, үйлчилгээг үйлдвэрлэлийн дотоод эргэлтэд ашигласнаас бусад хэлбэрээр бусдад үнэ төлбөргүй шилжүүлсэн буюу хувийнхаа хэрэгцээнд ашигласан бол нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөхгүй

¹² Энэ хуулийн 7.1.1, 7.1.2-т заасан бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын үнэлгээнд 10 хувиар ногдуулна

шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдалтай холбогдуулан 100.3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосон. Гэвч хяналт шалгалт хийсэн дүнг шалгалт тус бүрээр тайлагнаагүй, ямар төрлийн зөрчил дутагдал илэрсэн нь тодорхойгүй зөвхөн жилийн эцсийн тайлан мэдээнд тусгаж байна. Өөрөөр хэлбэл татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн байдалд хяналт тавьсан эсэх нь тодорхойгүй, хяналт хийгдээгүй байна.

2.2.2 Аймгийн Санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас ХХОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хяналт шалгалт хийж гарсан зөрчил дутагдлыг арилгуулах зөвлөмж хүргүүлсэн байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлогыг нийтэд хангалтгүй мэдээлсэн, зарим аж ахуйн нэгж байгууллага борлуулалтын орлогоо дутуу тайлагнаж, НӨАТ-аас чөлөөлөгдөх орлогыг илүү илэрхийлсэн зөрчил дутагдал илэрлээ
- ХХОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлтийг хуулийн дагуу хэрэгжүүлж байгаа боловч татварын дотоод хяналт хангалтгүй, цахим системийн мэдлэг дутмагаас аж ахуйн нэгж байгууллага борлуулалтын орлогоо илүү, дутуу тайлагнах, хөнгөлөлт, чөлөөлөлтийг буруу мэдээлэх зэрэг зөрчил гаргасан байна

ЗӨВЛӨМЖ

1. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбоотой хууль, тогтоол, журам, зааврын талаар иргэн, аж ахуйн нэгжид сургалт сурталчилгаа, зөвлөмж, мэдээлэлийг тухай бүр хүргэж байх
2. Татварын улсын байцаагчид, байгууллагын дотоод хяналтын нэгж татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хуулийн дагуу хяналт тавьж байх



СҮХБААТАР АЙМГИЙН
ТАТВАРЫН ХЭЛТЭС

22000 Баруун-Урт, Сүхбаатар аймаг
Утас, Факс: 70518484

2017.09.28 № 247

танай _____-ны № _____-т

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

“Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлого, түүний хэрэгжилт, үр дүн”-ийн талаарх танай байгууллагаас ирүүлсэн тайлангийн төсөлтэй танилцаж саналгүй болохыг үүгээр мэдэгдэж байна.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ М.ЭРДЭНЭ




Тайлан бичсэн:

Ахлах аудитор С.Ариунбаяр
Аудитор Б.Ариунзул
Аудитор Ө.Золзаяа

Хянасан:

Тэргүүлэх аудитор М.Нарантуяа
Аудитын менежер Г.Даваа





СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2017 оны 09 сарын 04 өдөр

Дугаар А/11

Баруун-Урт

Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2014 оны 03-р сарын 27-ны өдрийн 121 тоот тушаалаар батлагдсан “Нийслэлийн болон аймгийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт зөвшөөрөх бүрэн эрх”-ийн 5, 11, “Гүйцэтгэлийн аудитын журам”-ын 12 дугаар зүйлийн 12.40, “Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. “Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлого, түүний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

Хоёр. Тус аудитаар илрүүлсэн зөрчлийг арилгуулах албан шаардлагыг хавсралтаар баталгаажуулсугай.

Гурав. Аудитын тайланд тусгасан зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар авсан арга хэмжээ, түүний үр дүнг 2017 оны 11 дүгээр сарын 20-ны дотор ирүүлэхийг Сүхбаатар аймгийн Татварын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /М.Эрдэнэ/-д даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА